



## ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

Зоонозын халдварт өвчний долоо хоног тутмын мэдээлэл

### Дугаар №37



2018 оны 10-р сарын 29-нөөс, 11-р сарын 02

#### НЭГ. ТОХИОЛДОЛД СУУРИЛСАН ТАНДАЛТЫН МЭДЭЭ

Улсын хэмжээнд 2018 оны 11 дүгээр сарын 02-ний өдрийн байдлаар ЗӨСҮТ-д зоонозын халдварын хүний өвчлөлийн сэжигтэй байж болзошгүй нийт **1248** яаралтай дуудлагыг хүлээн авсан байна. Эдгээрийн 111(8.9%) галзуугийн эрсдэлд өртсөн, 1094(87.6%) хачигт халдвар, 24(1.9%) бэтэг, 2(0.2%) хумхаа, 1(0.1) денги, 10(0.8%) боом, 6(0.5%) тарваган тахлын хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдол эзэлж байна.

##### 1.1. Хачгаар дамжих халдварт өвчний сэжигтэй тохиолдол:



Архангай, Баянхонгор, Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Хөвсгөл, Ховд, Хэнтий, Дорнод, Дорноговь, Дундговь, Дархан-Уул, Өвөрхангай, Өмнөговь, Орхон, Завхан, Сэлэнгэ, Сүхбаатар, Увс, Төв аймгийн 106 сум, нийслэлийн 7 дүүрэгт хачгаар дамжих халдварын **1094** сэжигтэй тохиолдол мэдээлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 13%-иар бага байна. Эпидемиологийн 43-р долоо хоногтой харьцуулахад 1 сэжигтэй тохиолдлоор илүү байна.



Хачигт риккетсиозын 814 сэжигтэй тохиолдлын 199(24.4%), хачигт энцефалитын 185 сэжигтэй тохиолдлын 32(17.3%), хачигт боррелиозын 95 сэжигтэй тохиолдлын 24(25.3%) тархвар судлал, эмнэлзүй, лабораторийн шинжилгээгээр тус тус онош батлагдсан байна

##### 1.2. Галзуу өвчний эрсдэлд өртсөн тохиолдол:

Архангай, Баян-Өлгий, Ховд, Хөвсгөл, Хэнтий, Өвөрхангай, Өмнөговь, Говь-Алтай, Дундговь, Дорноговь, Завхан, Сэлэнгэ аймгийн 29 сум, нийслэлийн 4 дүүргээс галзуу өвчний эрсдэлд өртсөн нийт **111** тохиолдол мэдээлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 18%-иар бага байна. Эпидемиологийн 43-р долоо хоногтой харьцуулахад адил үзүүлэлттэй байна.



### 1.3 Бэтгийн хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдол:

ХӨСҮТ-өөс бэтэг өвчний онош тодруулахаар 5 хүний шинжилгээний материал ЗӨСҮТ-ийн лабораторит онош тодруулахад дээрх 5 хүний цусны ийлдсэнд бэтэг өвчний эсрэгбие IgG тодорхойлогдсон байна.

### 1.4 Боомын хүний өвчний сэжигтэй тохиолдол:

Дорнод аймгийн Халх гол суманд боомын арьсны хэлбэрийн хүний өвчлөлийн сэжигтэй 1 тохиолдол бүртгэгдсэн. Тархвар судлал, эмнэлзүйн шинж тэмдэг, лабораторийн шинжилгээгээр тохиолдол үгүйсгэгдсэн байна.

### 1.5 Денгийн хүний өвчлөлийн батлагдсан тохиолдол

Өвчтөн “А” 23 настай, эрэгтэй. Энэтхэг улсын Дели хотод амьдардаг. Сүүлийн 1 сард Дели хотоос гараагүй өгүүлэмжтэй. Гэр бүл болон ойр орчимд халуурсан ямар нэг зовиуртай хүн байхгүй. Халууралт нь тогтмол, 2018 оны 10-р сарын 26-наас халуурч 29-нд энэтхэг улсад байхдаа эмнэлэгт хандсан эмч Денгийн чичрэг байж магадгүй гээд парацетамол ууж ажиглахыг зөвлөсөн.

Монголд 10 дугаар сарын 30-нд ажлаар ирсэн. Онгоцонд явахдаа халуурч байсан. Түүнтэй хамт 3 хүн ирсэн ямар нэг зовиургүй байна. Улмаар 11-р сарын 01-ний өдөр Интермед эмнэлэгт хэвтсэн. Одоогийн өвчтний биеийн ерөнхий байдал хүндэвтэр, орчиндоо харьцаатай, хөдөлгөөн идэвхтэй, хордлогын шинжтэй, захын тунгалагийн булчирхай тэмтрэгдэхгүй, 2 нүд улайвтар, арьс салст чийглэг, арьсан дээр 2 хацар, дух, их бие, 2 гарны дотор талаар шигүүвтэр толбон гүвдрүүт улаан ягаан тууралттай, амин үзүүлэлтүүд хэвийн тогтвортой, уруул омголтсон, хэл хуурайвтар, гүйлсэн булчирхай улайлтгүй, хэвлий зөөлөн эмзэглэл үгүй, элэг, дэлүү тэмтрэгдэхгүй, хавангүй байна.


#### Хариу арга хэмжээ

- ЗӨСҮТ-ийн дуудлагын баг очиж өвчтөнд үзлэг хийж, лабоарторит сорьц дээжилсэн. Өвчтөний биеийн байдалд хяналт тавьж ажиллаж байна
- ЗӨСҮТ-ийн лабораторит ийлдэс судлалын шинжилгээгээр денгийн вирүсийн эсрэгбие IgM тодорхойлоход NTU=60.8 буюу эерэг дүнтэй тодорхойлогдсон. Молекул биологийн шинжилгээгээр өвчтөнөөс авсан сорьцонд денгийн вирүсийн үүсгэгч эерэг тодорхойлогдсон ба III серотип илэрсэн байна.
- Интермэд эмнэлэгт цахимаар “Денгийн чичрэг өвчний халдвараас сэргийлэх тухай” зөвлөмж, лабораторийн шинжилгээний хариуг хүргүүлсэн
- Эрсдэлийн үнэлгээ хийсэн (ШУН, халдвар хариуцсан баг)

- МХЕГ-ийн ХМХ-ын албатай мэдээлэл солилцон ажилласан.

### 1.5 Мэрэгч амьтны дуудлага:

Нийслэлийн 6 дүүрэгт (БЗД, БГД, ХУД, СБД, СХД, ЧД)-ээс мэрэгч амьтны нийт 93 дуудлаганд үйлчилсэн нь өмнөх оны мөн үеэс 16.1-иар их байна.



## ХОЁР. ТУХАЙН 7 ХОНОГТ БҮРТГЭГДСЭН ЗООНОЗЫН ШАЛТГААНТ ҮЙЛ ЯВДЛЫН МЭДЭЭ

### Олон улсад:

#### Африкийн гахайн мялзан өвчин:

БНХАУ-ын улсын Сарата хотын Guizhou мужид африкийн гахайн мялзан өвчин бүртгэгдэж, 10 гахай өртөмхий байснаас, 8 гахай өвчилж үхэн, 2 гахайг устгасан байна. Тус мужид хязгаарлалтын дэглэм тогтоожээ.



Эх сурвалж: ДАЭМБ

#### Шүлхий өвчин:


Коломба улсын Валледуфар хотын Сесар мужид “0” хэвшлийн вирусээр үүсгэгдсэн шүлхий өвчин гахайн аж ахуйд бүртгэгдэж, 128 гахай өртөмхий байснаас, 6 нь батлагдсан, 5 гахай өвчилж үхсэн байна. Тус мужид хорио цээрийн тогтоон ажилласан байна.



Эх сурвалж: ДАЭМБ

### Шувууны томуу өвчин:

БНХАУ-ын Юнлин хотод 10 дугаар сарын 20-ны байдлаар тус улсын Вэйганг мужид шувууны томуугийн А хүрээний H5N2 вирус халдвар шувууны аж ахуйд бүртгэгдэж 6315 шувуу өртөмхий байснаас, 2730 шувуу нь өвчилж үхэн, 3585 шувууг устгасан байна. Тус мужид хязгаарлалтын дэглэм тогтоон, тандалт судалгаа хийгдсэн байна.



Эх сурвалж: ДАЭМБ

ШУУРХАЙ УДИРДЛАГЫН НЭГЖ